



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 8/57

Хэрлэн сум

Х.Эрдэнэгарьдыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2022 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хашмаргадын Эрдэнэгарьдыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эдийн засаг, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2023 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Х.Эрдэнэгарьдын үндсэн цалинг ТЗ-8 зэрэглэлээр тогтоон, 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Эдийн засаг, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Х.Эрдэнэгарьдад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР